



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/03

Хараат

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай


Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэхь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн зөвшөөрөл батлах тухай 40 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Байгаль орчны байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт 5 дугаар, Бэлчээр тэжээл, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйг чанд сахин мөрдөж ажиллахыг төрийн захиргааны албан хаагчдад үүрэг болгосугай.

3. "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг төрийн захиргааны албан хаагчдад даалгасугай.

ДАРГА



З.СОЛОНГО

482002009